



## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2021 оны 07 сарын 09 өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

Монгол Ардын Намын улсын бүртгэлийн  
мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг  
бүртгэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Ч.Тунгалаг, шүүгч Б.Амарбаясгалан, М.Батсуурь, Б.Батцэрэн, Г.Банзрагч, П.Золзаяа, Д.Мөнхтуяа, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Х.Сонинбаяр, Б.Ундрах, Г.Цагаанцоож, Д.Цолмон, Б.Цогт, Ц.Цогт, Д.Эрдэнэбалсүрэн нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Монгол Ардын Намаас гаргасан тус намын улсын бүртгэл дэх мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгүүлэх тухай хүсэлтийг шүүгч Ц.Цогтын илтгэснээр хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Нэг. Монгол Ардын Намын дарга Л.Оюун-Эрдэнээс 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 288 тоот албан бичгээр Монгол Улсын дээд шүүхэд хандан “... Улаанбаатар хотноо 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдөр Монгол Ардын Намын Бага хурлын XI хуралдаан хагас цахимаар хуралдан Монгол Ардын Намын дарга Ухнаагийн Хүрэлсүх Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшин үнэмлэхүй олонхийн саналаар Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдон тангаргаа өргөсөн тул Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд заасны дагуу Монгол Ардын Намын даргын сонгуульт ажлаасаа чөлөөлөгдөж, Улс төрийн намын гишүүнчлэлээс түдгэлзсэн, хуралдаанд оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар Монгол Ардын Намын даргаар Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ миний бие сонгогдсон тул Монгол Ардын Намын бүртгэлд оруулсан өөрчлөлтийг хүлээн авч, бүртгэж өгнө үү” гэх өргөдөл гаргаж, өргөдөлдөө:

-Монгол Ардын Намын даргын бүртгэлд өөрчлөлт оруулах тухай хүсэлт /1 хуудас/

-Монгол Ардын Намын Удирдах Зөвлөлийн 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн “Монгол Ардын Намын Бага хурлыг хуралдуулах тухай” А/30 дугаар тогтоол /1 хуудас/

- Монгол Ардын Намын Бага хурлын XI хуралдааны тэмдэглэлээс /12 хуудас/,

- Монгол Ардын Намын Бага хурлын XI хуралдааны гишүүдийн ирц /9 хуудас/

- Монгол Ардын Намын Бага хурлын 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн “Монгол Ардын Намын даргыг чөлөөлөх тухай” 04 дүгээр тогтоол,

- Монгол Ардын Намын Бага хурлын XI хуралдааны тооллогын комиссын 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн “Монгол Ардын Намын даргад нэр дэвшүүлсэн нууц санал хураалтын дүнгийн тухай” 02 дугаар тогтоол,

- Монгол Ардын Намын Бага хурлын 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн “Монгол Ардын Намын даргыг сонгож батлах тухай” 05 дугаар тогтоол,
- Монгол Ардын Намын Бага хурлын 2021 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн “Монгол Ардын Намын Бага хурлын гишүүнээс чөлөөлөх тухай” 06 дугаар тогтоол /4 хуудас/,
- Монгол Ардын Намын Бага хурлын 2021 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн “Монгол Ардын Намын Бага хурлын гишүүнийг сонгож батлах тухай” 07 дугаар тогтоол /7 хуудас/,
- Л.Оюун-Эрдэнийн иргэний үнэмлэхний хуулбар
- Улсын бүртгэлийн гэрчилгээ /эх хувь/
- Улсын тэмдэгтийн хураамж 150,000 төгрөг тушаасан баримт болон холбогдох бусад баримтыг хавсарган ирүүлсэн байна.

Хоёр. Улс төрийн намын бүртгэл хөтлөх журмын 3.10-т зааснаар хүсэлт гаргагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Г.Баярбаатарыг оролцуулан 2021 оны 06 дугаар сарын 29, 07 дугаар сарын 06-ны өдөр сонсох ажиллагаа хийж холбогдох тодруулга, тайлбарыг авсан байна.

#### ХЯНАВАЛ:

Монгол Ардын Намын даргын өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт нь Улс төрийн намын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6, 10 дугаар зүйлийн 10.1.10-т тус тус зааснаар Улс төрийн намын улсын бүртгэл, хуулийн этгээдийн хувийн хэргийн агуулгад заавал тусгах мэдээлэлд хамаарч байна.

Монгол Ардын Намын дүрмийн 21.2-т “Намын Бага хурлын хуралдааныг Монгол Ардын Намын дарга, намын Удирдах Зөвлөлийн санаачлагаар, эсхүл намын Бага хурлын гишүүдийн гуравны нэг шаардсанаар зарлан хуралдуулж болно” гэж зааснаар тус намын Удирдах Зөвлөлийн 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/30 дугаар тогтоолоор намын Бага хурлаа 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдөр хуралдуулахаар зарласан нь дүрэмдээ нийцжээ.

Мөн дүрмийн 20.3.7-д “Намын Их хурлын чөлөөт цагт намын даргын орон гарвал Бага хуралд оролцсон гишүүдийн гуравны хоёрын саналаар шинэ даргыг сонгох” бүрэн эрхийг тус намын Бага хуралд олгосон байгаа тул намын даргыг чөлөөлж, сонгох асуудал нь Монгол Ардын Намын Бага хурлын эрх хэмжээнд хамаарч байна.

2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанд бүрэн эрхээ хэрэгжүүлж буй тус намын Бага хурлын 313 гишүүнээс 232 гишүүн оролцож, У.Хүрэлсүхийн “намын даргаас чөлөөлөгдөх” хүсэлт, мөн намын даргад нэр дэвшүүлэх, сонгох асуудлыг хэлэлцэж, гишүүдийн 100 хувийн саналаар У.Хүрэлсүхийг чөлөөлж, Л.Оюун-Эрдэнэ тус намын даргаар сонгогджээ. Энэ нь тус намын дүрмийн 21.5-д “Нийт гишүүдийн гуравны хоёроос илүү нь оролцож байгаа бол намын Бага хурлыг хүчинтэйд тооцно” гэсэнтэй,

Монгол Ардын Намын даргыг нууц санал хураалт явуулж сонгосон нь Улс төрийн намын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.14, 13 дугаар зүйлийн 13.3-т заасантай тус тус нийцжээ.

Түүнчлэн, тус намын даргын өөрчлөлт болон түүнийг бүртгүүлэхтэй холбоотой дотооддоо ямар нэгэн маргаангүй болох нь хүсэлт гаргагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн сонсох ажиллагааны явцад гаргасан тайлбарт дурьдагдсан бөгөөд энэ талаар ямар нэг гомдол, хүсэлт ирээгүй болно.

Иймд, Монгол Ардын Намын даргын өөрчлөлтийг тус намын улсын бүртгэлийн мэдээлэлд бүртгэж шийдвэрлэв.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ НЬ:

1. Улс төрийн намын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6, 22 дугаар зүйлийн 22.4-т заасныг баримтлан Монгол Ардын Намын Бага хурлын 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 11 дүгээр хуралдаанаар тус намын даргаар Хурц овгийн Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ (РД:ЧО80062919) сонгогдсон тухай өөрчлөлтийг Монгол Ардын Намын улсын бүртгэлийн мэдээлэлд бүртгэсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ  
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Ц.ЦОГТ